СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СБА-2024/155-НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баруун-Урт сум<br>2024 он | Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа<br>Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Нарантуяа<br>Утас: 99029193 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn<br>Аудитор: Ө.Золзаяа<br>Утас: 99055971 Цахим хаяг: zolzayau@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 5

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 11

**3.1 Төлбөрийн акт** ........ 11

**3.2 Зөвлөмж** ........ 11

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 12


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2024.02.25 № 94

танай ________ - ны№ __________ -т

СҮХБААТАР АЙМГИЙН
АСГАТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ М.УРАНТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 13.5 сая төгрөг, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 962.1 сая төгрөгийн санхүүжилт олгож, 828.3 сая төгрөг буюу 86 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 147.3 сая төгрөгийг тайланд толилуулсан байна. Төсөв захирагчийн өмнөх оны 13.5 сая төгрөгийн үлдэгдлийг дээд шатны байгууллагаас зарцуулах асуудлыг шийдвэрлээгүйтэй холбоотой өмнөх оны үлдэгдэл тайлант оны эцэст зарцуулагдаагүй үлджээ.

**Аудитын гол асуудал**

Тус сургуулийн 1-5 дугаар ангийн суралцагчдын үдийн хоолны батлагдсан нормативд зардал, хүүхэд өдрөөр гарсан гүйцэтгэлийн зөрүүгээс үүссэн төсвийн

үлдэгдлээс 6.3 сая төгрөгийн хүнсний материал нөөцөлж, 5.9 сая төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлэлгүй үлдэгдлээр илэрхийлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус сургуулийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 62 арга хэмжээг төлөвлөж, 60 арга хэмжээ хэрэгжсэн байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дээд шатны байгууллагаас 94.6 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ДАВАА

D:/Bichig hereg/2023/A4 toot

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **102,793,438.80** | **224,380,185.97** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 13,582,621.79 | 147,350,821.96 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 13,582,621.79 | 147,350,821.96 |
| **3121** | **Төгрөг** | 13,582,621.79 | 147,350,821.96 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 13,582,621.79 | 147,350,821.96 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 89,210,817.01 | 77,029,364.01 |
| **354** | **Хангамжийн материал** | 75,560,817.01 | 71,809,364.01 |
| 35420 | Аж ахуйн материал | 8,953,454.21 | 11,035,754.21 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 165,000.00 | 281,820.00 |
| 35460 | Хүнсний материал | 37,040.00 | 6,333,249.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 66,405,322.80 | 54,158,540.80 |
| 35600 | Мал амьтад | 13,650,000.00 | 5,220,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,885,096,253.12** | **1,875,886,923.38** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,885,096,253.12 | 1,875,886,923.38 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,858,550,253.12 | 1,849,700,923.38 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,729,997,330.91 | 1,729,997,330.91 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (151,413,003.02) | (202,708,369.70) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 6,000,000.00 | 6,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (3,900,000.00) | (4,500,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 238,364,787.20 | 317,467,187.20 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (47,421,935.46) | (98,634,355.47) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 80,888,620.00 | 121,378,620.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (15,535,752.23) | (41,487,100.02) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,927,500.00 | 3,927,500.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (2,092,001.64) | (2,577,500.00) |
| 39217 | Ном | 19,734,707.36 | 20,837,610.46 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 26,546,000.00 | 26,186,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (360,000.00) | (720,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 25,672,636.00 | 25,672,636.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (566,636.00) | (566,636.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,987,889,691.92** | **2,100,267,109.35** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,758,043.30** | **1,583,069.03** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 3,758,043.30 | 1,583,069.03 |
| **413** | **Өглөг** | 3,758,043.30 | 1,583,069.03 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 3,078,043.30 | 1,583,069.03 |
| **4136** | **Бусад өглөг** | 680,000.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 680,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,984,131,648.62** | **2,098,684,040.32** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,984,131,648.62 | 2,098,684,040.32 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 287,712,364.56 | 287,712,364.56 |
| 51101 | Өмч: - төрийн | 287,712,364.56 | 287,712,364.56 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,681,512,574.06 | 1,796,064,965.76 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (302,424,164.16) | 1,681,512,574.06 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,983,936,738.22 | 114,552,391.69 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 14,906,710.00 | 14,906,710.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,987,889,691.92** | **2,100,267,109.35** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,793,011,229.96** | **1,121,423,318.10** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,047,362,718.12** | **117,044,518.10** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,047,362,718.12 | 117,044,518.10 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,047,362,718.12 | 117,044,518.10 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,417,300.00 | 1,199,800.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,857,400.00 | 23,818,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,043,088,018.12 | 92,026,718.10 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **745,648,511.84** | **1,004,378,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 658,282,100.00 | 962,078,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 658,282,100.00 | 962,078,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 87,366,411.84 | 42,300,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 87,366,411.84 | 42,300,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **808,993,206.31** | **1,003,883,426.39** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **808,993,206.31** | **1,003,883,426.39** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 760,614,061.60 | 964,477,380.37 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 505,925,484.42 | 618,354,004.78 |
| 210101 | Үндсэн цалин | 391,001,306.58 | 433,343,610.98 |
| 210102 | Нэмэгдэл | 87,777,712.48 | 163,320,488.52 |
| 210104 | Урамшуулал | 27,146,465.36 | 21,689,905.28 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 63,947,317.77 | 76,562,003.79 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,764,484.92 | 52,039,988.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,109,057.26 | 6,271,857.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,062,492.25 | 5,013,166.06 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,001,043.99 | 1,210,285.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,010,239.35 | 12,026,706.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34,907,894.16 | 37,111,701.64 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,833,144.76 | 14,692,886.72 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 18,625,249.40 | 17,417,514.92 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,449,500.00 | 5,001,300.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,980,070.00 | 8,880,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 935,070.00 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 10,045,000.00 | 8,880,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 32,462,139.75 | 37,293,464.34 |
| 210502 | Хоол, хүнс | 32,462,139.75 | 37,293,464.34 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,384,030.00 | 4,608,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,384,030.00 | 4,608,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,003,500.00 | 6,104,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,417,300.00 | 1,199,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,586,200.00 | 4,905,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 98,003,625.50 | 175,563,105.82 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,205,870.00 | 32,114,413.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,011,900.00 | 7,411,560.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 72,785,855.50 | 136,037,132.82 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 48,379,144.70 | 39,406,046.02 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 44,931,986.36 | 39,326,897.66 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 38,449,886.36 | 39,326,897.66 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,482,100.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 3,447,158.34 | 79,148.36 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,447,158.34 | 79,148.36 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,984,018,023.65** | **117,539,891.71** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 81,285.43 | 2,987,500.02 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 81,285.43 | 2,987,500.02 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (81,285.43) | (2,987,500.02) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,983,936,738.22** | **114,552,391.69** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **749,923,211.84** | **1,029,396,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,274,700.00** | **25,017,800.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,274,700.00 | 25,017,800.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 4,274,700.00 | 25,017,800.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,417,300.00 | 1,199,800.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,857,400.00 | 23,818,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **745,648,511.84** | **1,004,378,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 658,282,100.00 | 962,078,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 658,282,100.00 | 962,078,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 87,366,411.84 | 42,300,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 87,366,411.84 | 42,300,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **719,631,909.05** | **855,431,399.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **719,631,909.05** | **855,431,399.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **671,181,563.85** | **812,679,258.81** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 505,925,484.42 | 618,354,004.78 |
| 210101 | Үндсэн цалин | 391,001,306.58 | 433,343,610.98 |
| 210102 | Нэмэгдэл | 87,777,712.48 | 163,320,488.52 |
| 210104 | Урамшуулал | 27,146,465.36 | 21,689,905.28 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 63,947,317.77 | 76,562,003.79 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,764,484.92 | 52,039,988.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,109,057.26 | 6,271,857.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,062,492.25 | 5,013,166.06 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,001,043.99 | 1,210,285.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,010,239.35 | 12,026,706.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 33,778,441.66 | 37,228,521.64 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,833,144.76 | 14,692,886.72 |
| 210302 | Түлш, халаалт | 17,495,796.90 | 17,614,334.92 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,449,500.00 | 4,921,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 30,807,700.00 | 40,244,438.60 |
| 210502 | Хоол, хүнс | 30,807,700.00 | 40,244,438.60 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,000,000.00 | 4,992,330.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,000,000.00 | 4,992,330.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,903,500.00 | 6,104,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,417,300.00 | 1,199,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,486,200.00 | 4,905,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,819,120.00 | 29,193,160.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,351,820.00 | 21,641,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,467,300.00 | 7,551,760.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **48,450,345.20** | **42,752,141.02** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 45,003,186.86 | 42,672,992.66 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 38,521,086.86 | 42,672,992.66 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,482,100.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 3,447,158.34 | 79,148.36 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,447,158.34 | 79,148.36 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **30,291,302.79** | **173,965,200.17** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **16,708,681.00** | **40,197,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **16,708,681.00** | **40,197,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 16,708,681.00 | 40,197,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 16,708,681.00 | 40,197,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(16,708,681.00)** | **(40,197,000.00)** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 13,582,621.79 | 133,768,200.17 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 13,582,621.79 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 13,582,621.79 | 147,350,821.96 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 287,712,364.56 | 14,906,710.20 | 302,619,074.76 | 0.00 | 605,238,149.52 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -1,829,360,744.04 | 0.00 | -1,829,360,744.04 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **287,712,364.56** | **14,906,710.20** | **-1,526,741,669.28** | **0.00** | -1,224,122,594.52 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 1,983,936,738.22 | 0.00 | 1,983,936,738.22 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **287,712,364.56** | **14,906,710.20** | **457,195,068.94** | **0.00** | 759,814,143.70 |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **287,712,364.56** | **14,906,710.20** | **457,195,068.94** | **0.00** | 759,814,143.70 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **287,712,364.56** | **14,906,710.20** | **457,195,068.94** | **0.00** | 759,814,143.70 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 114,552,391.69 | 0.00 | 114,552,391.69 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **287,712,364.56** | **14,906,710.20** | **571,747,460.64** | **0.00** | **874,366,535.40** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,043,512,800.00 | 895,549,251.47 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,043,512,800.00 | 895,549,251.47 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 994,949,900.00 | 852,876,258.81 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 741,867,000.00 | 618,354,004.78 |
| 210101 | Үндсэн цалин | 504,418,500.00 | 433,343,610.98 |
| 210102 | Нэмэгдэл | 208,333,900.00 | 163,320,488.52 |
| 210104 | Урамшуулал | 29,114,600.00 | 21,689,905.28 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 92,733,500.00 | 76,562,003.79 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63,058,800.00 | 52,039,988.33 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,418,600.00 | 6,271,857.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,935,000.00 | 5,013,166.06 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,483,700.00 | 1,210,285.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,837,400.00 | 12,026,706.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,300,000.00 | 37,228,521.64 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,800,000.00 | 14,692,886.72 |
| 210302 | Түлш, халаалт | 20,000,000.00 | 17,614,334.92 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,500,000.00 | 4,921,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 41,177,400.00 | 40,244,438.60 |
| 210502 | Хоол, хүнс | 41,177,400.00 | 40,244,438.60 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,000,000.00 | 4,992,330.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 4,992,330.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,049,900.00 | 6,104,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 1,199,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,049,900.00 | 4,905,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 71,822,100.00 | 69,390,160.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 64,247,200.00 | 61,815,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,574,900.00 | 7,574,760.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 48,562,900.00 | 42,672,992.66 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 48,562,900.00 | 42,672,992.66 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 48,562,900.00 | 42,672,992.66 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,005,883,700.00 | 1,005,578,600.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,005,883,700.00 | 1,005,578,600.00 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 1,005,883,700.00 | 1,005,578,600.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 13,582,621.79 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 147,350,821.96 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 101.6 сая төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 12.7 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 88.9 сая төгрөгийн хүнсний материалын худалдан авах ажиллаатай холбоотой 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 12.7 сая төгрөгийн материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 7.4 сая төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

3.1.1 Тус сургуулийн 1-5 дугаар ангийн суралцагчдын үдийн хоолны батлагдсан нормативд зардал, хүүхэд өдрөөр гарсан гүйцэтгэлийн зөрүүгээс үүссэн төсвийн үлдэгдлээс 6.3 сая төгрөгийн хүнсний материал нөөцөлж, 5.9 сая төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлэлгүй үлдэгдлээр илэрхийлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах), Боловсролын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 (Энэ хуулийн 38.1.2, 38.1.3-т заасан гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг боловсролын сургалтын байгууллага дараагийн төсвийн жил дамжин зарцуулж болно), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 (нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх) гэсэн заалтуудыг зөрчсөнд төлбөрийн акт тогтоолоо.

3.1.2 Тус сургуулийн үндсэн багшаас бусад ажилтнуудад 0.5 сая төгрөгийн дата багцыг олгож, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар баталсан зааврыг мөрдөөгүй байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;), Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ын 2.4 дэх заалтуудыг зөрчсөнд төлбөрийн акт тогтоолоо.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Тайлант онд 1-5 дугаар ангийн суралцагчдын үдийн хоол хөтөлбөрийн 47.7 сая, дотуур байрны хүүхдийн хоол хүнсний төсвийн 41.2 сая нийт 88.9 сая төгрөгийн хүнсний материалын худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;), Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 (Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална), 7 дугаар зүйлийн 7.1 (Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна) дахь

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

заалтыг тус тус зөрчсөн ба үнэн зөв байх, иж бүрэн, тохиолдсон байх батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны хүнсний материалыг нэр төрлөөр багцалж хууль, журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Үдийн хоолны төсвийн үлдэгдлийг төвлөрүүлээгүй | 1 | 12,223.2 | 1 | 12,223.2 | | | | | | | | |
| Дата багцыг илүү олгосон | 1 | 510.0 | 1 | 510.0 | | | | | | | | |
| Хүнсний материалын ХАА-г зохион байгуулаагүй | 1 | 88,942.8 | | | | | 1 | 88,942.8 | | | | |
| Дүн | 3 | 101,676.0 | 2 | 12,733.2 | | | 1 | 88,942.8 | | | | |